



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБА


**2024 оны эхний хагас жилийн үйл  
ажиллагааны тайлан**

2024 он

**ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

Тайлангийн хамрах хугацаа: 2024 оны 1-06 сар

Тайлан илгээгч:

БУЛГАН АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН  
АЛБАНЫ ДАРГА  Б.БАТТУЛГА



Боловсруулсан:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН

АХЛАХ БАЙЦААГЧ

А.АНХБАЯР

Хүлээн авагч:

САНГИЙН ЯАМНЫ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН  
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ДОРЖСЭМБЭД

### Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны мэдээлэл

Орон тоо	8
Дарга	1
СХШУАБ	1
СХШУБ	3
Ахлах дотоод аудитор	-
Дотоод аудитор	2
Нягтлан бодогч, бичиг хэрэг	0,5
Жолооч, нярав	0,5
Төсөв	394,868.4

### Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Нийт арга хэмжээ	
Биелэлтийн хувь	

### Дотоод аудит, хяналт шалгалтын төрөл

Хяналт шалгалтын төрөл				Нийт хяналт шалгалтын тоо
Өргөдөл гомдлоор	Дотоод аудит	Санхүүгийн хяналт шалгалт	Хамтарсан	
	16	23	5	41
Хангал сумын Хялганат тосгоны Соёлын төв /Соёл урлагийн газраас ирсэн албан бичгийн дагуу/		1		1
Булган аймгийн хөгжимт жүжгийн театр /Булган аймгийн Соёл урлагийн газар, Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу/		1		1
Булган АЗЗА ТӨХК /Зам тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу/		1		1
/ Сайхан сумын Засаг даргын тамгын газарт /Сайхан сумын				1

иргэн Б.Цэрэннадмидаас ирүүлсэн өргөдлийн дагуу/		1		1
Бугат сумын ЗДТГ /Авилгатай тэмцэх газраа ирүүлсэн 05-9058 тоот албанбичгийн дагуу/		1		1
<b>Дүн</b>	<b>16</b>	<b>28</b>	<b>5</b>	<b>49</b>

#### Хяналт шалгалтын мэдээлэл

Акт		Албан шаардлага		Нийт хяналт шалгалтын тоо	Нийт зөрчлийн дүн
Тоо	Дүн /мянган төгрөгөөр/	Тоо	Дүн /мянган төгрөгөөр/		
41	22,366.5	24	128,019.5	49	218

### 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024.07.08

#### **Нэг.Үндсэн үйл ажиллагааны талаар**

Төсвийн тухай хууль, дотоод аудитын дүрмийг баримтлан төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын зарцуулалт зэрэгт дотоод аудит явуулах, эрсдэлийн удирдлагаар ханган дүгнэлт зөвлөмж боловсруулах, үр дүнг тайлагнах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, дотоод аудитын үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчлах зэрэг ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллалаа.

Албаны дарга 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч 3, дотоод аудитор 2, нягтлан бодогч, архив бичиг хэргийн ажилтан 0,5, жолооч, нярав 0,5 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.


#### **Хоёр. Үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийн Ерөнхийлөн захирагчийн өгсөн үүрэг чиглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлууд**

Булган аймгийн санхүүгийн хяналт дотоод аудитын алба нь 2023 онд 6 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, хагас жилийн байдлаар 5 зорилт 43 арга хэмжээний хэрэгжилт 90,8 хувьтай байна.

Аймгийн ИТХ-ын хуралдаанд Шилэн дансны 2023 оны жилийн эцсийн тайланг хэлэлцүүлж ИТХ-ын тогтоол гаргуулан хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.



Төсвийн Ерөнхийлөн захирагчаар 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хяналт шалгалтын графикаа батлуулан ажиллаж байна. Байгууллагын дарга “2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г батлуулсантай холбогдуулан төрийн захиргааны албан хаагчид төрийн жинхэнэ албан хаагчид 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан албаны даргаар батлуулаа.



Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг холбогдох хууль, стандарт, дүрэм, журмын хүрээнд, батлагдсан төсөвт багтаан зохион байгуулан ажиллаж байна .

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь төрийн ажил үйлчилгээг сайжруулах, төрийн алба хаагчдын харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой иргэдийн санал, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхийн зэрэгцээ <http://sankhuuhyanalt.bu.gov.mn> хаягаар өргөдөл гомдлыг хүлээн авч байна.

Төсвийн тухай хуулийн 69.3. "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна." заалт, Засгийн газрын 2016 оны 483 дүгээр тогтоол, Аудитын хорооны даргын баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Тайлант онд 16 сумын хоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны санхүү үйл ажиллагаанд дотоод аудит, Номын сан, Музей, Булган соёлын төв, Соёл урлагийн газар, Спортын дунд сургууль, Хутаг-Өндөр, Тэшиг, Орхон сумдын төсөвт байгууллагуудын 2023 оны санхүү үйл ажиллагаанд төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалтыг Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2023-2024 оны 1 дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагаанд, Зам тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Булган АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд, Сайхан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүү үйл ажиллагаанд, хялганат тосгоны соёлын төвийн 2022 оны санхүү үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус


хяналт шалгалтыг, Сумдын ойн анги болон байгаль хамгаалах сангуудын үйл ажиллагаанд ИТХ-тай хамтарсан хяналт шалгалтыг хийсэн.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу 23 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралтай хамтран сумдын ойн анги болон байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалтыг хийж, улсын ахлах байцаагчийн 41 актаар 22,366.5 мянган төгрөгийн төлбөр тогтоож, 128,019.6 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн 24 албан шаардлага хүргүүлсэн байна. Тайлант онд тавигдсан актын төлбөрөөс 21 байгууллагын 9,011.6 мянган төгрөгийн актын төлбөрийг, өмнөх оны актын төлбөрөөс 13,971.9 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 128,019.6 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн 24 албан шаардлагаас 18 байгууллагын 34,577.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулж, 3 байгууллагын 81,458.9 мянган төгрөгийн албан шаардлагын үлдэгдэл байна. /Тоон тайланд зөрчлийн ангилал, албан шаардлага, актын төлбөрийн талаар тодорхой байгаа тул дурдаагүй/

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Төсвийн Ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад тухай бүр, сар, улирал бүр хяналт тавьж илэрсэн зөрчлийг цаг тухай бүр нь засуулан мэдээ тайлан нэгтгэн холбогдох газруудад хүргүүлэн дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласны дүнд шилэн дансны нэгдсэн системд бүртгэлтэй байгууллагын мэдээлсэн байдал 99,5 хувьтай тайлагнасан. Шилэн дансны хуулийн хэрэгжилт, илэрсэн зөрчлийн талаарх мэдээллийг шалгагдсан бүх сум байгууллагад хийсэн. Хутаг-Өндөр, Тэшиг сумдын ИТХ-тай албан байгууллагын дарга албан хаагчид болон иргэдэд “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч, сургалт зохион байгуулсан.

“Дотоод аудитын удирдлагын мэдээллийн систем”-д дотоод аудит хийсэн 16 багууллагын мэдээллийг бүрэн шивж оруулсан, санхүүгийн хяналт шалгалт хийсэн 23 багууллагаас 13 байгууллагын мэдээллийг бүрэн шивж оруулаад байна.

Жагсаалт

Аудит үүсгэх 

Үр дүн: 18 Хайлт: ; Аудитын төрөл: Дотоод аудит

#	Аудитын код	Аудитын нэр	Аудитын төрөл	Аудитын ангилалын нэр	Төлөв	Аудитын төлөвлөгөөнд суурилсан эсэх	Аудитын төлөвлөгөөний нэр	Төлөвлөсөн эхлэх жил
1	100001882	Дашинчилэн сумын Хоршоо хөгжүүлэх сангийн до	Дотоод аудит	Санхүүгийн аудит	Хүлээгдэж байгаа	Тийм		2024
2	100001901	Рашаант сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2023	Дотоод аудит	Санхүүгийн аудит	Шинэ	Тийм		2024
3	100002310	Булган аймгийн Орхон сумын Хоршоо хөгжүүлэх с	Дотоод аудит	Санхүүгийн хяналт ш	Шинэ	Тийм		2024
4	100002307	Булган аймгийн Орхон сумын Хоршоо хөгжүүлэх с	Дотоод аудит	Бусад	Шинэ	Тийм		2024
5	100002264	Булган аймгийн Орхон сумын хоршоо хөгжүүлэх с	Дотоод аудит	Бусад	Шинэ	Тийм		2024
6	100001925	Тэшиг сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны	Дотоод аудит	Гүйцэтгэлийн аудит	Батлагдсан	Тийм		2024
7	100001923	хишигөндөр сумын хоршоо хөгжүүлэх сангийн 202	Дотоод аудит	Гүйцэтгэлийн аудит	Батлагдсан	Тийм		2024
8	100001922	баяннуур сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2023	Дотоод аудит	Гүйцэтгэлийн аудит	Батлагдсан	Тийм		2024
9	100002165	Бүрэгхангай сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 20	Дотоод аудит	Гүйцэтгэлийн аудит	Батлагдсан	Тийм		2024
10	100002167	Могод сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны	Дотоод аудит	Гүйцэтгэлийн аудит	Батлагдсан	Тийм		2024
11	100001607	Хангал сумын хоршоо хөгжүүлэх сан	Дотоод аудит	Гүйцэтгэлийн аудит	Цуцлагдсан	Тийм		
12	100001887	Булган сумын хоршоо хөгжүүлэх сангийн2023 оны	Дотоод аудит	Гүйцэтгэлийн аудит	Шинэ	Тийм		2024
13	100001621	Хангал сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 он	Дотоод аудит	Үйл ажиллагааны ауд	Батлагдсан	Тийм		2024
14	100001841	Сэлэнгэ сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 он	Дотоод аудит	Санхүүгийн аудит	Батлагдсан	Тийм		2024
15	100001902	Бугат сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны	Дотоод аудит	Гүйцэтгэлийн аудит	Шинэ	Тийм		2024
16	100001900	Гурванбулаг сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2	Дотоод аудит	Гүйцэтгэлийн аудит	Шинэ	Тийм		2024
17	100001884	Сайхан сумын хоршоо хөгжүүлэх сан 2023 он дото	Дотоод аудит	Санхүүгийн аудит	Шинэ	Тийм		2024
18	100001883	Баян-Агт сумын хоршоо хөгжүүлэх сан 2023 оны Д	Дотоод аудит	Санхүүгийн аудит	Шинэ	Тийм		2024



#	Аудитын код	Аудитын нэр	Аудитын төрөл	Аудитын ангилалын нэр	Төлөв	Аудитын төлөвлөгөөнд суурилсан эсэх	Аудитын төлөвлөгөөний нэр	Төлөвлөсөн эхлэх жил
1	100002232	Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн	Санхүүгийн хяналт	Бусад	Батлагдсан	Тийм		2024
2	100002233	Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн	Санхүүгийн хяналт	Бусад	Батлагдсан	Тийм		2024
3	100002234	Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн	Санхүүгийн хяналт	Бусад	Батлагдсан	Тийм		2024
4	100002235	Аймгийн ИТХ-ын 2024 оны үйл ажиллагааны төлөв	Санхүүгийн хяналт	Хамтарсан	Батлагдсан	Тийм		2024
5	100002306	Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн	Санхүүгийн хяналт	Бусад	Батлагдсан	Тийм		2024
6	100002313	Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн	Санхүүгийн хяналт	Бусад	Батлагдсан	Тийм		2024
7	100002317	Аймгийн ИТХ-ын 2024 оны үйл ажиллагааны төлөв	Санхүүгийн хяналт	Бусад	Батлагдсан	Тийм		2024
8	100002363	Санхүүгийн хяналт	Санхүүгийн хяналт	Санхүүгийн хяналт	Шинэ	Тийм		2024
9	100002328	Тэшиг сумын Соёлын төвийн 2023 оны санхүүгийн	Санхүүгийн хяналт	Санхүүгийн хяналт	Шинэ	Тийм		2024
10	100002143	Төлөвлөгөөт хяналт шалгалт	Санхүүгийн хяналт	Санхүүгийн хяналт	Батлагдсан	Тийм		2024
11	100002133	Төлөвлөгөөт хяналт шалгалт	Санхүүгийн хяналт	Санхүүгийн хяналт	Батлагдсан	Тийм		2024
12	100002142	Төлөвлөгөөт хяналт шалгалт	Санхүүгийн хяналт	Санхүүгийн хяналт	Батлагдсан	Тийм		2024
13	100002182	Хутаг-өндөр сумын "ИЛЧИТ ХУТАГ" ОНӨХХК-ны 20	Санхүүгийн хяналт	Санхүүгийн хяналт	Шинэ	Тийм		2024
14	100002173	Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай	Санхүүгийн хяналт	Санхүүгийн хяналт	Шинэ	Тийм		2024

**Гурав. Сангийн яам болон холбогдох бусад байгууллагаас ирүүлсэн чиглэл, үүрэг даалгаврын дагуу хийж гүйцэтгэсэн ажлууд**

Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн батлагдаж ирээгүй байна.

**Дөрөв. Хууль тогтоомж, дүрэм журам, стандартын төсөлд нэмэлт өөрчлөлтийн санал болон бусад мэдээ тайлан судалгааг холбогдох байгууллагад хүргүүлсэн талаар**

Аймгийн Засаг даргыг үнэн зөв мэдээллээр ханган, удирдлагын тогтолцоог төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулсан. Байгууллагын шуурхай зөвлөгөөнийг 7 хоног тутам зохион байгуулж, өгсөн үүрэг даалгаварын биелэлтэд хяналт тавьж, шуурхай үүргийн биелэлтийг хүргэн байгууллагатай холбогдолтой цаг үеийн асуудлаар тогтмол хуралдаж асуудлыг танилцуулж шийдвэрлэж байна.

Аймгийн удирдах ажилтаны шуурхай зөвлөгөөнөөр өгөгдсөн үүрэг даалгаваруудыг 100% ханган ажиллаж, тухай бүр хугацаанд нь биелэлтийг хүргүүлсэн.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан Монгол бичгийн мэдлэгээ ахиулах, төрийн албан хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх төлөвлөгөөнүүдийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан.

Хяналт шалгалт хийх бүртээ ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ илэрхийлсэн мэдүүлгийг гаргаж, Шилэн дансны нэгдсэн сайтад тухай бүр бүрэн мэдээлсэн.

Хөрөнгө орлогын мэдүүлгийг 2 дугаар сарын 10-ны дотор [www.meduuleg.iaac.mn](http://www.meduuleg.iaac.mn) сайтад цахимаар мэдүүлж аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдүүлгийг бүртгэх, хянах эрх бүхий албан тушаалтанд цаасаар хүргүүлж, бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зурж баталгаажуулсан.

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Төрийн албаны зөвлөлийн программд оруулсан бөгөөд Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүний нөөцтэй холбоотой шаардлагатай мэдээ, судалгааг цаг тухай бүрт нь гаргаж өгч байна.

Өмнөх оны төсвийн тайлагналт, төсөв санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт, шалгалтын дүнд тулгуурлан санхүүгийн хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулан, Аудитын хорооны тогтоолоор батлуулан бүх сум, байгууллагуудад хүргүүлсэн.


**Тав. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийн дагуу хийсэн хяналт шалгалтууд**

Булган аймгийн Соёл урлагийн газар, Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 1/04 тоот удирдамжаар Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2023-2024 оны 1 дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж улсын ахлах байцаагчийн 2 актаар 788,5 мянган төгрөгийн актын төлбөр тогтоогдсоныг хугацаанд нь барагдуулсан, Зам тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Булган АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж танилцуулгыг өргөдөл гаргагч харьяалах дээд байгууллага, иргэн болон тухайн байгууллагад хүргүүлсэн мөн Улсын ахлах байцаагчийн 1 актаар 1,181.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдсоныг бүрэн төлж барагдуулсан. Булган аймаг дахь Төрийн аудитын газраас 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн аудитаар эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас Шүүхийн шийдвэрийн дагуу “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын захирал С.Баярсайханд 10,137.4 мянган төгрөгийн цалинг Тэшиг сумын Засаг даргын тамгын газраас гаргасан зөрчлийг 2024 онд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэн тухайн иргэнээс хохирлыг барагдуулж байгууллагыг хохиролгүй болгосон.

**Зургаа. Бусад болон дотоод үйл ажиллагааны талаар**

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах ажлын хүрээнд Дотоод аудитын удирдлагын мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэхтэй холбоотой дараах сургалтуудыг 2024 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр цахимаар Удирдлага болон Админ эрхтэй албан хаагч нарт зориулсан сургалтад, 1 сарын 5-ны өдөр Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нарт зориулсан сургалтад албаны албан хаагчид 100%-ийн ирцтэй хамрагдлаа.

2024 оны 03 сарын 21, 22-нд Орхон аймагт Хэнтий болон Булган аймгийн санхүүгийн хяналт дотоод аудитын албаны албан хаагчид “Нэгдсэн менежмент тогтолцоо” стандарт нэвтрүүлсэн сайн туршлага сургалт, санхүүгийн хяналт шалгалт дотоод аудит, шинээр нэвтрүүлж буй “Дотоод аудитын удирдлагын мэдээллийн систем”-ийн талаар санал солилцон, туршлага судаллаа.



Хяналт шалгалт болон үйл ажиллагаа, цалин хөлстэй холбоотой баримт 2023 оны баримт материалыг байгууллагын 2020 оны баримт бичиг хөтлөх хэргийн нэрийн



жагсаалтын дагуу байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжээр ялган үдэж архивласан.

Албан хаагчдын өдөр бүрийн цагийн ирцийн бүртгэлийг албан хэрэг хөтлөлтийг нүүр танигч төхөөрөмжөөр бүртгэж байна.

Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын сургалтын төлөвлөгөөний дагуу, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх чиглэлээр бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамруулж ажилласан. Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжил”-ийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан Орхон аймгийн Засаг даргын тамгын газар, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт хамтран Хангайн бүсийн аймгуудын нягтлан бодогч, санхүүч, эдийн засгийн ажилтнуудын “Мэргэжлийн тасралтгүй хөгжил-2024” сургалт зөвлөгөөнийг 2024 оны 4 сарын 12-наас 13-ны өдрүүдэд Орхон аймагт зохион байгуулагдсан сургалт зөвлөгөөнд хамрагдсан. Тус зөвлөгөөнд Булган, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл, Дархан аймгуудын Төрийн аудитын газар, Санхүүгийн хяналт дотоод аудитын алба, төрийн байгууллагуудын 450 гаруй төлөөлөгч оролцлоо.



Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын баталсан “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, орон нутагт цахим шилжилтийг эрчимжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудад мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх “Цахимд хэвшье” уриатай “Digital firstD1” арга хэмжээ 4 сарын 24-нд Булган аймагт зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд хамт олноороо оролцлоо.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу байгууллагын дэргэд Ёс зүйн дэд хороо байгуулагдсан дэд хорооны ажиллах журмыг танилцуулах цахим сургалтад 5 албан хаагч хамрагдсан. Байгууллагын Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

#### ***Долоо. Хөндлөнгийн мониторинг болон сэтгэл ханамжийн судалгаа***

Хөндлөнгийн үнэлгээ, хэрэглэгчийн үнэлгээ авах ажлыг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн ба өөрийн сайт болон нүүр номдоо санал асуулгын хуудсаар авч байна.

Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд ил тод нээлттэй байдлаар явагдаж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, зөвлөгөө өгөх байдал, санхүүгийн хяналт шалгалтын үр дүн хангалттай, харилцаа хандлага

сайн байгааг илэрхийлж байгаа боловч мэдээ мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулсан.

Төсөв санхүүгийн үйл ажиллагааны талаар: 2024 оны эхний хагас жилд тус алба нь нийт 187,5 сая төгрөгийн санхүүжилттэйгээр үйл ажиллагаагаа явуулж буй бөгөөд төсвийг зориулалтын дагуу, үр өгөөжтэй зарцуулан ажиллалаа.

Өмч хамгаалах байнгын комисс томилон санхүүгийн тайлан гаргах, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, ажилтан албан хаагчдын хөрөнгө ашиглалтын бүртгэлийг тулган баталгаажуулан тоолж үндсэн хөрөнгө бараа материалыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу данс бүртгэлд бүртгэсэн.

Мөн харилцагч байгууллагуудтай сар, улирал бүр тооцоо нийлж тайлан, мэдээгээ хуулийн хугацаанд тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг бүрэн ашиглаж байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд мэдээллийг 100 хувь хугацаа хоцроолгүй мэдээлэн, хугацаанд нь илгээн тайлагнасан. Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу албаны төсөв, санхүүгийн мэдээ, тайланг хуулийн хугацаанд нь [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) нэгдсэн цахим сайт болон шилэн дансны мэдээллийн самбарт тогтмол байршуулан албан хаагч болон иргэдэд шаардлагатай мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. Шилэн дансны мэдээлсэн байдлыг сар бүр удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд мэдээлсэн.

2024 оны төсөвт тусгагдсан эх үүсвэрээс суурин компьютер 3 ширхэг. Авто машин худалдан авах төсвийг батлуулж төсөвт суулгуулан байгууллага авто тээврийн хэрэгсэлтэй болж өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн байгууллагын үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгаж авсан.

### ***Найм. Дүгнэлт***

Тус алба нь төсвийн хөрөнгө, өр, төлбөр орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт зэрэг төсвийн бүрдүүлэлт түүний зарцуулалтад төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гарган эрсдэлийн удирдлагаар хангасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгууллагын үндсэн үйл ажиллагааг хангах зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Албан тушаалын тодорхойлолт, Засаг даргаас баталсан удирдамжийн дагуу байгууллагын санхүү, дотоод үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд аудит хийж, дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартыг даган мөрдөн ёс зүй, сахилгын зөрчилгүй ажилласан.

### ***Ес. Санал***

Цаашид байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх аудитын зөвлөмж дүгнэлтийн хэрэгжилтийг хангахад санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, чадвараа тасралтгүй дээшлүүлэн хөгжүүлэх боломжийг ханган мэргэшүүлэх сургалтыг улсын салбарын дотоод аудиторын тодорхой сэдэвчилсэн сургалтыг үе шаттай зохион


байгуулах, албаны үйл ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдсэн дотоод үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэн, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, төсөл хөтөлбөрт хамруулах.

Дотоод аудитын удирдлагын мэдээллийн нэгдсэн системд шивэлт хийхэд бусад байцаагч нарын шивж байгаа мэдээлэл нь бусад байцаагч нартаа харагдаж байна энэ нь байдлыг арилгах талаар тайлан шивэлтийн алдаа дутагдлын талаар байцаагч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө тусламжийг үзүүлэх, сургалт зохион байгуулах.

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБАНЫ  
ДАРГА  Б.БАТТУЛГА

ТАЙЛАН БИЧСЭН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ  А.АНХБАЯР